



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/102НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.23 № 120
танай _____ -ны № _____ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хүүхэд өдрийн төлөвлөгөө 26,250 өдрөөр батлагдаж гүйцэтгэлээр 18,473 хүүхэд буюу 70.4 хувьтай, улсын төсвөөс 705,054.0 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 4 дүгээр түвшинд 3 багш, 5 дугаар түвшинд 2 багш үнэлэгдсэн байна.

Тайлант онд сумын түүхт 100 жилийн ойг болж үе үеийн багш, ажилчид, төгсөгчид 96.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил болон хүүхдийн тоглоом, бараа материал, мал хандивласныг тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)
(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>147,558,838.64</u>	<u>95,275,540.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,420,306.65	37,431,994.09
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	107,420,306.65	37,431,994.09
3121	Төгрөг	107,420,306.65	37,431,994.09
31211	Төрийн сангийн харилцах	107,420,306.65	37,431,994.09
33	АВЛАГА	1,167,738.49	869,953.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	875,238.49	577,453.18
335	Бусад авлага	292,500	292,500
3351	Байгууллагаас авах авлага	292,500	292,500
34	УРЬДЧИЛГАА	1,000,000	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,000,000	-
34713	Цалингийн урьдчилгаа	1,000,000	-
35	БАРАА МАТЕРИАЛ	37,970,793.50	56,973,593.50
351	Түүхий эд материал	173,700	-
35130	Эм боох материал	173,700	-
354	Хангамжийн материал	37,797,093.50	56,973,593.50
35410	Бичиг хэргийн материал	857,500	3,875,500
35420	Аж ахуйн материал	21,482,543.50	33,977,943.50
35450	Барилгын засварын материал	200,000	200,000
35460	Хүнсний материал	6,724,200	10,387,300
35470	Бусад хангамжийн материал	8,532,850	8,532,850
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>759,043,439.19</u>	<u>815,449,964.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	759,043,439.19	815,449,964.02
392	Биет хөрөнгө	745,416,839.19	801,823,364.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	802,810,440	817,810,440
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,139,738.82)	(163,157,665.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	26,567,359
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,934,077	133,709,603
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,220,513.22)	(70,117,696.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,795,580.82	86,919,934.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,433,984.59)	(32,579,588.44)
39217	Ном	2,670,978	2,670,978
393	Биет бус хөрөнгө	13,626,600	13,626,600
39301	Програм хангамж	587,000	587,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(587,000)	(587,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,626,600	13,626,600
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>906,602,277.83</u>	<u>910,725,504.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>509,910</u>	<u>1,289,925.85</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	509,910	1,289,925.85
413	Өглөг	509,910	1,289,925.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	779,715.85
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	225,000	225,300
4136	Бусад өглөг	284,910	284,910
41361	Байгууллагад төлөх өглөг	284,910	284,910
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>906,092,367.83</u>	<u>909,435,578.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	906,092,367.83	909,435,578.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,972,543	190,972,543
51101	Өмч: - төрийн	190,972,543	190,972,543
512	Хуримтлагдсан үр дүн	357,903,875.24	361,325,724.15
51210	Өмнөх үеийн үр дүн	357,903,875.24	357,982,513.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,343,211.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,215,949.59	357,137,311.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>906,602,277.83</u>	<u>910,725,504.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	828,835,345	888,421,245
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,686,045	118,853,145
120	Нийтлэг татварын бус орлого	54,686,045	118,853,145
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,686,045	118,853,145
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,615,600	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,070,445	118,853,145
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,149,300	769,568,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	711,680,600	705,745,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,680,600	705,745,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,468,700	63,823,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,468,700	63,823,100
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	768,050,497.85	885,078,033.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,050,497.85	885,078,033.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	760,963,650.67	885,077,918.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	523,257,081.26	622,697,049.70
210101	Үндсэн цалин	350,793,046.60	400,032,466.70
210102	Нэмэгдэл	160,658,684.66	194,554,883
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,040,000
210104	Урамшуулал	11,805,350	16,069,700
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,580,916.38	76,519,533.02
210201	Тэтгэврийн даатгал	45,770,349.70	52,833,922.55
210202	Тэтгэмжийн даатгал	5,206,851.53	6,126,379.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,126.05	3,063,190.15
210204	Ажилгүйдлийн даатгал	2,569,852.05	2,869,275.78
210205	Эрүүл мэндийн даатгал	10,433,737.05	11,626,765.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,657,756.82	61,622,984.88
210301	Гэрэл, цахилгаан	4,083,756.82	6,058,784.88
210302	Түлш, халаалт	55,254,750	55,255,200
210303	Цэвэр, бохир ус	319,250	309,000
2104	Хангамж, бараа материалын зардал	5,802,300	-
210401	Бичиг хэрэг	2,771,600	-
210402	Тээвэр, шатахуун	3,030,700	-
2105	Нормативт зардал	61,694,390	55,854,300
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	478,000	173,700
210502	Хоол, хүнс	61,216,390	55,680,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,200,000
210604	Урсгал засвар	-	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,310,000	945,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,440,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,870,000	945,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,661,206.21	65,239,051.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,849,930.00	19,390,220
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,874,211
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,811,276.21	41,974,620.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,086,847.18	115.12

2132	Бусад урсгал шилжүүлэг	5,589,600	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,589,600	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,497,247.18	115.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,497,247.18	115.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>60,784,847.15</u>	<u>3,343,211.11</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>60,784,847.15</u>	<u>3,343,211.11</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>784,764,900</u>	<u>769,568,100</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,615,600	-
120	Нийтлэг татварын бус орлого	10,615,600	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,615,600	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,615,600	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,149,300	769,568,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	711,680,600	705,745,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,680,600	705,745,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,468,700	63,823,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,468,700	63,823,100
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>747,888,574.96</u>	<u>839,556,412.56</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,888,574.96	839,556,412.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,801,727.78	839,556,297.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,199,536.96	621,164,081.56
210101	Үндсэн цалин	355,848,046.30	374,369,163.86
210102	Нэмэгдэл	156,765,540.66	218,704,629
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,040,000
210104	Урамшуулал	13,585,950	16,050,288.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,260,733	73,799,400
210201	Тэтгэврийн даатгал	43,843,943	50,188,500
210202	Тэтгэмжийн даатгал	5,116,040	5,904,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,552,410	2,953,500
210204	Ажилгүйдлийн даатгал	2,552,410	2,953,500
210205	Эрүүл мэндийн даатгал	10,195,930	11,799,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,895,452.82	61,622,984.88
210301	Гэрэл, цахилгаан	4,321,452.82	6,058,784.88
210302	Түлш, халаалт	55,254,750	55,255,200
210303	Цэвэр, бохир ус	319,250	309,000
2105	Нормативт зардал	48,239,900	58,953,400
210502	Хоол, хүнс	48,239,900	58,953,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,076,000	2,200,000
210604	Урсгал засвар	1,076,000	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,310,000	945,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,440,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,870,000	945,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,820,105	20,871,431
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,230,505	15,605,720

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,589,600	5,265,711
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,086,847.18	115.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,589,600	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,589,600	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,497,247.18	115.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,497,247.18	115.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>36,876,325.04</u>	<u>(69,988,312.56)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	36,876,325.04	(69,988,312.56)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		107,420,306.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	107,420,306.65	37,431,994.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543	357,215,949.59	297,119,028.09	845,307,520.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,972,543	357,215,949.59	297,119,028.09	845,307,520.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	60,784,847.15	60,784,847.15
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543	357,215,949.59	357,903,875.24	906,092,367.83
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,972,543	357,215,949.59	357,903,875.24	906,092,367.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	78,637.80	78,637.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,972,543	357,215,949.59	357,982,513.04	906,171,005.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(78,637.80)	-	(78,637.80)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,343,211.11	3,343,211.11
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543	357,137,311.79	361,325,724.15	909,435,578.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	870,257,700	839,556,297.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	870,257,700	839,556,297.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	870,257,700	839,556,297.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	636,501,300	621,164,081.56
210101	Үндсэн цалин	386,801,600	374,369,163.86
210102	Нэмэгдэл	235,589,500	218,704,629
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,040,000
210104	Урамшуулал	14,110,200	16,050,288.70

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,145,100	73,799,400
210201	Тэтгэврийн даатгал	53,685,100	50,188,500
210202	Тэтгэмжийн даатгал	6,365,000	5,904,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,182,500	2,953,500
210204	Ажилгүйдлийн даатгал	3,182,500	2,953,500
210205	Эрүүл мэндийн даатгал	12,730,000	11,799,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,003,100	61,622,984.88
210301	Гэрэл, цахилгаан	7,147,800	6,058,784.88
210302	Түлш, халаалт	55,255,300	55,255,200
210303	Цэвэр, бохир ус	600,000	309,000
2105	Нормативт зардал	60,623,000	58,953,400
210502	Хоол, хүнс	60,623,000	58,953,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,200,000	2,200,000
210604	Урсгал засвар	2,200,000	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,077,900	945,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,077,900	945,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,707,300	20,871,431
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,440,800	15,605,720
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,266,500	5,265,711
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	773,988,500	769,567,984.88
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	708,785,400	705,745,000
131001	Улсын төсвөөс санхүүжих	708,785,400	705,745,000
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,203,100	63,822,984.88
132001	Орон нутгийн төсвөөс	65,203,100	63,822,984.88
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		107,420,306.65
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,431,994.09

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 25,978.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 25,978.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүй элэгдэл тооцоогүй, худалдан авсан хөрөнгө, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 12,950.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Бараа материалын тайлангд 450.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэсэн,
- Адталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 78.6 мянган төгрөгөөр орхигдуулсан ,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг, тайлант үеийн үр дүнг 12,500 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 1 зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1 зөрчил² илэрснээс, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 6494 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж,ирцийн бүртгэлд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	4	25,978.5	1	78.5	3	25,900.0	4	25,978.6	-	-	-	-
Дүн	4	25,978.5	1	78.5	3	25,900.0	4	25,978.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	1	-					1		-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-